



## ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2024/49/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Говьсүмбэр аймаг 2023 он	Дарга тэргүүлэх аудитор: Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn  Аудитын менежер: Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn  Ахлах аудитор: Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn
---------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2024.08.23 № 30

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

0008020104

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд 148, нийтлэг чиг үүргийн хүрээнд 14, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 29 арга хэмжээ тус тус төлөвлөж, жилийн эцсийн байдлаар 90.2 хувьтай хэрэгжжээ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,110,285,273.84</b>	<b>974,841,388.77</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>59,617,537.20</b>	<b>36,750,408.40</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>59,617,537.20</b>	<b>36,750,408.40</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>59,617,537.20</b>	<b>36,750,408.40</b>
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	59,617,537.20	36,750,408.40
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,655,093.94</b>	<b>53,324,926.67</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>1,655,093.94</b>	<b>53,324,926.67</b>
33510	Байгууллагаас авах авлага	1,655,093.94	53,324,926.67
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>57,628,867.50</b>	<b>15,191,702.00</b>
34200	Төсөвт байгууллага	57,628,867.50	8,105,702.00
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	7,086,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>991,383,775.20</b>	<b>869,574,351.70</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,493,150.00</b>	<b>0.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	1,493,150.00	0.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>989,890,625.20</b>	<b>869,574,351.70</b>
35410	Бичиг хэргийн материал	672,500.00	188,000.00
35420	Аж ахуйн материал	26,531,439.20	16,081,484.20
35440	Түлш, шатах тослох материал	2,299,710.00	5,307,280.00
35450	Барилгын засварын материал	49,973,444.00	3,200,000.00
35470	Бусад хангамжийн материал	910,413,532.00	844,797,587.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,117,227,268.55</b>	<b>5,495,461,980.31</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,117,227,268.55</b>	<b>5,495,461,980.31</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,476,998,114.43</b>	<b>3,383,195,064.83</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,960,036,240.88	2,958,946,240.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-339,646,082.32	-434,894,862.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	530,330,000.00	688,330,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-245,561,652.77	-351,458,708.33
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	721,176,625.32	799,923,348.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-279,400,470.34	-383,176,844.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	194,743,031.50	199,126,479.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64,679,577.84	-93,600,588.24
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,640,229,154.12</b>	<b>2,112,266,915.48</b>
39301	Програм хангамж	4,780,000.00	4,780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,537,000.02	-3,300,666.70
39303	Бусад биет бус хөрөнгө	1,813,790,357.00	2,420,695,561.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-175,804,202.86	-309,907,978.82
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,227,512,542.39</b>	<b>6,470,303,369.08</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>265,000.00</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>265,000.00</b>	<b>0.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>265,000.00</b>	<b>0.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>265,000.00</b>	<b>0.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	265,000.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,227,247,542.39</b>	<b>6,470,303,369.08</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>6,227,247,542.39</b>	<b>6,470,303,369.08</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,841,055,631.25	2,841,055,631.25
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,841,055,631.25	2,841,055,631.25
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>776,306,667.54</b>	<b>1,665,126,618.54</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,189,701,243.13	1,375,297,347.35

51220	Тайлант үеийн үр дүн	-413,394,575.59	289,829,271.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,609,885,243.60	1,964,121,119.29
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,227,512,542.39</b>	<b>6,470,303,369.08</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,069,699,941.50</b>	<b>4,460,813,967.08</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>159,234,564.00</b>	<b>1,266,907,084.18</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>159,234,564.00</b>	<b>1,266,907,084.18</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>37,723,200.00</b>	<b>1,321,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,723,200.00	1,321,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	91,847,364.00	867,667,610.18
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	29,664,000.00	397,918,474.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,910,465,377.50</b>	<b>3,193,906,882.90</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>259,177,777.50</b>	<b>129,703,682.90</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	206,722,429.00	30,227,477.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,455,348.50	99,476,205.90
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,651,287,600.00</b>	<b>3,064,203,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,651,287,600.00	3,064,203,200.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,483,094,517.09</b>	<b>4,170,984,695.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,483,094,517.09</b>	<b>4,170,984,695.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,868,738,071.46</b>	<b>3,611,635,932.79</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>745,638,392.43</b>	<b>1,382,577,328.38</b>
210101	Үндсэн цалин	593,722,102.70	1,367,070,610.53
210102	Нэмэгдэл	101,076,056.44	15,498,717.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,142,369.00	8,000.00
210104	Урамшуулал	22,696,011.00	0
210105	Гэрээт ажлын хөлс	13,001,853.29	0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>89,136,304.88</b>	<b>163,586,938.52</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,050,836.13	141,008,652.18
210202	Тэтгэмжийн даатгал	9,543,592.04	5,800,933.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,328,181.61	4,596,746.75
210204	Ажилгүйдлийн даатгал	1,733,862.26	1,056,383.07
210205	Эрүүл мэндийн даатгал	18,479,832.84	11,124,223.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>141,544,851.52</b>	<b>151,893,616.91</b>
210301	Гэрэл, цахилгаан	28,389,967.52	28,491,730.70
210302	Түлш, халаалт	99,020,744.00	106,583,609.00
210303	Цэвэр, бохир ус	14,134,140.00	16,818,277.21
210304	Байрны түрээс	0	0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>160,803,640.00</b>	<b>365,482,503.11</b>
210401	Бичиг хэрэг	13,007,963.00	14,629,200.00
210402	Тээвэр, шатахуун	39,594,303.00	54,474,610.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,256,276.00	6,335,617.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	620,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,000.00	177,680.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	100,105,098.00	256,415,601.50
210408	Бараа материал акталсны зардал	0	32,829,794.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,084,361.00</b>	<b>298,323,280.00</b>
210604	Урсгал засвар	22,084,361.00	298,323,280.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>24,149,320.00</b>	<b>62,252,297.80</b>

210702	Дотоод албан томилолт	21,720,000.00	52,760,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,429,320.00	9,492,297.80
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>232,198,507.00</b>	<b>181,187,539.15</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,070,718.00	171,699,563.72
210803	Даатгалын үйлчилгээ	5,565,000.00	4,868,587.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	415,273.00	374,348.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	220,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,661,500.00	2,693,024.43
210807	Газрын төлбөр	1,332,016.00	1,332,016.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,453,182,694.63</b>	<b>1,006,332,428.92</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	901,437,353.57	479,750,237.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,651,920.00	3,467,093.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	547,093,421.06	523,115,098.42
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>614,356,445.63</b>	<b>559,348,763.10</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>52,921,700.00</b>	<b>61,539,700.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	52,921,700.00	61,539,700.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>110,560,666.00</b>	<b>59,599,634.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,913,372.00	0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0	28,750,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,456,950.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	59,190,344.00	30,849,634.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>450,874,079.63</b>	<b>438,209,429.10</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	435,237,529.63	393,320,660.10
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,636,550.00	44,888,769.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-413,394,575.59</b>	<b>289,829,271.19</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-413,394,575.59</b>	<b>289,829,271.19</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,963,453,577.50</b>	<b>3,254,120,875.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>37,940,200.00</b>	<b>1,321,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>37,940,200.00</b>	<b>1,321,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>37,940,200.00</b>	<b>1,321,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,940,200.00	1,321,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,925,513,377.50</b>	<b>3,252,799,875.90</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>274,225,777.50</b>	<b>188,596,675.90</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	206,722,429.00	87,856,344.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	67,503,348.50	100,740,331.90
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,651,287,600.00</b>	<b>3,064,203,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,651,287,600.00	3,064,203,200.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,924,523,977.50</b>	<b>3,243,305,804.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,924,523,977.50</b>	<b>3,243,305,804.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,249,125,664.37</b>	<b>2,671,451,539.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>745,418,144.66</b>	<b>1,382,690,547.97</b>
210101	Үндсэн цалин	472,876,125.60	725,845,298.16
210102	Нэмэгдэл	167,960,759.77	417,821,702.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,006,206.00	54,116,046.69
210104	Урамшуулал	49,464,786.00	165,790,044.97
210105	Гэрээт ажлын хөлс	16,110,267.29	19,117,456.14
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>88,516,068.62</b>	<b>163,429,394.66</b>
210201	Тэтгэврийн даатгал	61,767,193.88	112,820,294.43
210202	Тэтгэмжийн даатгал	6,928,211.68	12,977,725.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,335,105.85	10,263,380.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,246,598.00	2,348,042.22
210205	Эрүүл мэндийн даатгал	13,238,959.21	25,019,952.63
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>141,101,146.04</b>	<b>152,129,179.58</b>
210301	Гэрэл, цахилгаан	27,946,262.04	28,252,093.37
210302	Түлш, халаалт	98,106,204.00	108,302,590.00
210303	Цэвэр, бохир ус	15,048,680.00	15,574,496.21
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>71,216,617.00</b>	<b>94,416,312.61</b>
210401	Бичиг хэрэг	12,569,963.00	17,945,950.00
210402	Тээвэр, шатахуун	39,250,800.00	54,088,080.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,201,276.00	6,342,617.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	718,600.00	620,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,475,978.00	15,419,665.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>45,233,321.00</b>	<b>65,124,579.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,666,700.00	7,299,650.00
210604	Урсгал засвар	40,566,621.00	57,824,929.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>24,149,320.00</b>	<b>64,377,697.80</b>
210702	Дотоод албан томилолт	21,720,000.00	51,886,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,429,320.00	12,491,697.80
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>217,507,440.00</b>	<b>182,919,130.48</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	205,159,651.00	173,431,155.05
210803	Даатгалын үйлчилгээ	5,565,000.00	4,868,587.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	415,273.00	374,348.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	220,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,881,500.00	2,693,024.43
210807	Газрын төлбөр	1,332,016.00	1,332,016.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>915,983,607.05</b>	<b>566,364,697.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	911,081,687.05	562,897,604.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,901,920.00	3,467,093.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>675,398,313.13</b>	<b>571,854,265.10</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>52,921,700.00</b>	<b>61,539,700.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	52,921,700.00	61,539,700.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>113,973,666.00</b>	<b>63,999,434.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,913,372.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	28,750,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,456,950.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,603,344.00	35,249,434.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>508,502,947.13</b>	<b>446,315,131.10</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	435,237,529.63	393,320,660.10
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	73,265,417.50	52,994,471.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>38,929,600.00</b>	<b>10,815,071.20</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>28,552,600.00</b>	<b>33,682,200.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>28,552,600.00</b>	<b>33,682,200.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>28,552,600.00</b>	<b>33,682,200.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,552,600.00	33,682,200.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-28,552,600.00</b>	<b>-33,682,200.00</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>10,377,000.00</b>	<b>-22,867,128.80</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	49,240,537.20	59,617,537.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	59,617,537.20	36,750,408.40

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,841,055,631.25	2,609,885,243.60	776,306,667.54	6,227,247,542.39
2	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,841,055,631.25	2,609,885,243.60	776,306,667.54	6,227,247,542.39
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	598,990,679.81	598,990,679.81
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,841,055,631.25	2,609,885,243.60	1,375,297,347.35	6,826,238,222.20
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-645,764,124.31	0.00	-645,764,124.31
6	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	289,829,271.19	289,829,271.19
7	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,841,055,631.25	1,964,121,119.29	1,665,126,618.54	6,470,303,369.08

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,064,853,200.00</b>	<b>2,672,203,539.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,064,853,200.00</b>	<b>2,672,203,539.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,788,872,300.00</b>	<b>2,546,664,405.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,373,375,400.00</b>	<b>1,362,729,822.97</b>
210101	Үндсэн цалин	788,229,200.00	713,678,050.16
210102	Нэмэгдэл	435,826,200.00	411,446,777.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,320,000.00	53,172,046.69
210104	Урамшуулал	115,000,000.00	165,315,492.97
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	19,117,456.14
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>183,080,900.00</b>	<b>160,934,302.66</b>
210201	Тэтгэврийн даатгал	143,294,900.00	110,325,202.43
210202	Тэтгэмжийн даатгал	9,946,300.00	12,977,725.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,957,300.00	10,263,380.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,989,300.00	2,348,042.22
210205	Эрүүл мэндийн даатгал	19,893,100.00	25,019,952.63
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>169,994,300.00</b>	<b>152,129,179.58</b>
210301	Гэрэл, цахилгаан	34,261,300.00	28,252,093.37
210302	Түлш, халаалт	122,723,000.00	108,302,590.00
210303	Цэвэр, бохир ус	13,010,000.00	15,574,496.21
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>98,314,000.00</b>	<b>94,416,312.61</b>
210401	Бичиг хэрэг	18,750,000.00	17,945,950.00
210402	Тээвэр, шатахуун	55,650,000.00	54,088,080.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,864,000.00	6,342,617.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,050,000.00	620,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,000,000.00	15,419,665.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>100,000,000.00</b>	<b>98,806,779.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,000,000.00	34,117,150.00
210602	Тавилга	7,000,000.00	6,864,700.00
210604	Урсгал засвар	58,000,000.00	57,824,929.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>73,980,000.00</b>	<b>64,377,697.80</b>
210702	Дотоод албан томилолт	53,980,000.00	51,886,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	20,000,000.00	12,491,697.80
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>255,127,700.00</b>	<b>116,800,612.48</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	145,000,000.00	107,312,637.05
210803	Даатгалын үйлчилгээ	4,872,000.00	4,868,587.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	391,600.00	374,348.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	281,000.00	220,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	102,833,300.00	2,693,024.43
210807	Газрын төлбөр	1,749,800.00	1,332,016.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>535,000,000.00</b>	<b>496,469,698.80</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	525,000,000.00	493,002,605.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	3,467,093.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>275,980,900.00</b>	<b>125,539,134.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>61,539,700.00</b>	<b>61,539,700.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	61,539,700.00	61,539,700.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>214,441,200.00</b>	<b>63,999,434.00</b>

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	150,000,000.00	28,750,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,120,600.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,320,600.00	35,249,434.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,064,853,200.00</b>	<b>2,672,203,539.90</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,064,203,200.00</b>	<b>2,670,882,539.90</b>
320001	Орон нутгийн төсвөөс	3,064,203,200.00	2,670,882,539.90
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>650,000.00</b>	<b>1,321,000.00</b>
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	650,000.00	1,321,000.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>61.00</b>	<b>53.00</b>
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	41.00	33.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>61.00</b>	<b>53.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	34.00	27.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	2.00	2.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	21.00	20.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	4.00	4.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Мөнгөн дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>188,596,675.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>188,596,675.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>135,602,204.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>19,960,725.0</b>
210101	Үндсэн цалин	12,167,248.0
210102	Нэмэгдэл	6,374,925.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	944,000.0
210104	Урамшуулал	474,552.0
210105	Гэрээт ажлын хөлс	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,495,092.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,495,092.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>66,118,518.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,118,518.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>47,027,869.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,027,869.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>52,994,471.0</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>52,994,471.0</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	52,994,471.0
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>188,596,675.9</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>188,596,675.9</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	87,856,344.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,740,331.9

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

### **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Дээрх чиглэл, зааврыг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1 Аймгийн Засаг даргын 2023 оны А/126-р захирамжаар БНСУ-ын Сөүл хот руу албан томилолтоор зорчихдоо Kogean air компанийн нислэгээр зорчсон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ” гэж заасныг зөрчсөн тул алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2 Албан тушаалын автомашинд тод дэвсгэр бүхий улсын дугаар хэрэглээгүй.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэж заасныг зөрчсөн тул хуулийн хэрэгжилтийг хангуулахаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

### **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын 265,768.9 мянган төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө зарцуулах 235,123.9 мянган төгрөгийн 23 тушаал шийдвэрийг мэдээлээгүй 93 тушаалыг хугацаа хоцроосон, таван сая дээш зарлагын 30,645.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.5, 6.4.8-т заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй мэдээллийг нөхөн оруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **Залруулсан алдаа:**

1. Барилгын засварын материал дансанд 2020 онд 38,788.0 мянга, 2019 онд 7,985.4 мянган төгрөгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрөөний засварын ажлыг тус тус үлдэгдлээр тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад залруулсан.
2. Мобиком, Скайтел ХХК-нийн сайтын цахилгааны төлбөрийг сар бүр тооцоо үүсгэж бүртгээгүй. 2022 оны 11 сарын цахилгааны төлбөрийг ЗДТГ-ын төсвөөс төлж 2023 оны 04 сард нэхэмжилж авсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, санхүүгийн тайлангийн тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад залруулсан.
3. Аймгийн 30 жилийн ойд зориулан 3700ш зургийн цомгийг 52,725.0 мянган төгрөгөөр хийлгэх гэрээг Боржигин нутгийн зураг ХХК-тай байгуулж хүлээн авсан акт үйлдсэн боловч биетээр номыг хүлээлцээгүй, авлага үүсгэж бүртгээгүй байна.
4. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар

зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" 26 дугаар зүйлийн 26.1 "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг тус тус зөрчсөн тул аудитаар залруулсан.

Аудитаар нийт 581.7 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 581.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгсөн.

## **5.1 Төлбөрийн акт**

5.1.1 Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтөд хийсэн түүвэрчилсэн тулгалтаар 16 албан хаагчид 226.0 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү, 22 албан хаагчид 236.9 мянган төгрөгийн хөнгөлөлтийг дутуу эдлүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Илүү эдлүүлсэн хувь хүний орлогын алба татварын хөнгөлөлт 226.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, дутуу эдлүүлсэн 236.9 мянган төгрөгийн хөнгөлөлтийг албан хаагчдад буцаан олгох

5.1.2 Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр 118.8 мянган төгрөгийн нүүрсний хөнгөлөлт олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1, 6.6.2, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэргүй олгосон нүүрсний хөнгөлөлт болох 118.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

## **5.2 Албан шаардлага өгөөгүй.**

### **5.3 Зөвлөмж**

#### **1. Газар эзэмших эрхтэй холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт Аймгийн Засаг даргын 2021 оны А/61 тоот захирамжаар "Цахилгааны дэд станц" зориулалтаар олгосон 3000м2 газрын эзэмших эрхийг үнэлж бүртгээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших эрхийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх

#### **2. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал**

1.3. Илрүүлэлт Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн 124 нэр төрлийн 276 ширхэг, 365,650.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дах заалт, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгөнөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгэх

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
АЗДТГ	3	52.7	1	52.7	2	-	3	52,725.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>52.7</b>	<b>1</b>	<b>52.7</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>52,725.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
									Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
АЗДТГ	4	0.6	2	0.6	-	2	-					
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>0.6</b>	<b>2</b>	<b>0.6</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
АЗДТГ	1	265.8			1	265.8		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>265.8</b>			<b>1</b>	<b>265.8</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
АЗДТГ	3	46.9			3	46.9		
Дүн	3	46.9			3	46.9		
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>312.7</b>			<b>4</b>	<b>312.7</b>		

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				

A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	1	1			1			